



МЭДРЭЛИЙН МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ГОРИЛОГЧИД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

АХЛАХ зэрэг горилогчид тавигдах тусгай шаардлага:

1. Сүүлийн 5 жилийн хугацаанд ажиллаж буй байгууллагынхаа эмнэлгийн мэргэжилтнүүдэд **3**-аас доошгүй удаа мэдрэлийн эмгэгтэй холбоотой мэдээлэл өгсөн, илтгэл тавьсан, сургалт зохион байгуулсан байх, үүнийг байгууллагын удирдлагаар баталгаажуулсан байх.
2. Мэдрэл судлалын мэргэжлийн сэтгүүл, дотоодын ба олон улсын хурлын илтгэлийн хураангуй номонд хэвлүүлсэн **3** ба түүнээс дээш мэдрэл судлалын судалгааны өгүүлэл туурвисан байх, үүний 1 ба түүнээс дээш бүтээлийн 1-р зохиогч байх.
3. Өдөр тутмын практик туршлагад тулгуурласан **1** ба түүнээс дээш эмнэлзүйн ханан/аман илтгэл тавьсан байх.
4. Мэдрэл судлалын сэтгүүлд **1** ба түүнээс дээш эмнэлзүйн тохиолдол хэвлүүлсэн байх.
5. Мэдрэлийн эмгэгийн талаар эмчлүүлэгч, ар гэр, иргэдэд зориулсан зөвлөмж **5** ба түүнээс дээш гаргасан байх.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогчид тавигдах тусгай шаардлага:

1. Сүүлийн 5 жилийн хугацаанд мэдрэл судлалын мэргэжлийн сэтгүүл, дотоодын ба олон улсын хурлын илтгэлийн хураангуй номонд хэвлүүлсэн мэдрэл судлалын чиглэлээр **5** ба түүнээс дээш судалгааны өгүүлэл туурвисан байх, үүний 2 ба түүнээс дээш бүтээлийн 1-р зохиогч байх.
2. Өдөр тутмын практик туршлагад тулгуурласан **5** ба түүнээс дээш эмнэлзүйн ханан/аман илтгэл дотоодын ба олон улсын хуралд тавьсан байх.
3. Мэргэжлийн сэтгүүлд **3** ба түүнээс дээш эмнэлзүйн ховор тохиолдол хэвлүүлсэн байх.
4. Мэдрэлийн эмгэгийн талаар ном, гарын авлага **2** ба түүнээс дээш гаргасан байх.
5. Мэдрэлийн төрөлжсөн мэргэшүүлэх **1-2** сургалтанд хамрагдаж мэргэжлээ дээшлүүлсэн байх, жишээ нь, тархины цахилгаан бичлэг, тархины судасны хэт авиан шинжилгээ, мэдрэл-булчингийн цахилгаан шинжилгээ.

ЗӨВЛӨХ зэрэг горилогчид тавигдах тусгай шаардлага:

1. Мэдрэл судлалын чиглэлээр сүүлийн 15 жилд **10** ба түүнээс дээш судалгааны өгүүлэл туурвисан байх, судалгааны 5 ба түүнээс дээш өгүүллийн 1-р зохиогч, эсхүл судалгааны хариуцлагатай зохиогч байх.
2. Өдөр тутмын практик туршлагад тулгуурласан **10** ба түүнээс дээш эмнэлзүйн ханан/аман илтгэл дотоодын ба олон улсын хуралд тавьсан байх.
3. Мэргэжлийн сэтгүүлд **10** ба түүнээс дээш эмнэлзүйн ховор тохиолдол хэвлүүлсэн байх.
4. Мэдрэлийн эмгэгийн заавар, стандарт багадаа 2-ыг боловсруулсан буюу шинэчилсэн байх, ном, гарын авлага багадаа 3 гаргасан байх.
5. Мэдрэлийн төрөлжсөн мэргэшүүлэх багадаа **2** сургалтанд хамрагдаж мэргэжлээ дээшлүүлсэн байх, жишээ нь, тархины цахилгаан бичлэг, тархины судасны хэт авиан шинжилгээ, мэдрэл-булчингийн цахилгаан шинжилгээ.